



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2018 оны 06 сарын 20 өдөр

Дугаар 1/247

Улаанбаатар хот

Г Мэдээлэл, сургалт сурталчилгаа хийх
ажлын төлөвлөгөө батлах тухай Г

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8.1.21 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах зорилгоор ТУШААХ нь:

1. Хүн амыг уламжлалт анагаах ухааны аргаар эрүүл мэндээ хамгаалах, сайжруулах мэдлэг, арга барилтай болгох мэдээлэл, сургалт, сурталчилгаа хийх ажлын төлөвлөгөөг нэгдүгээр, шаардагдах төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлыг төлөвлөгөөний дагуу нэгдсэн зохион байгуулалтаар хангаж, иргэдийн хандалт өндөртэй олон нийтийн хэвлэл, мэдээллийн байгууллагуудтай гэрээ байгуулах, үйл ажиллагааг Эрүүл мэндийг дэмжих сангаас санхүүжүүлэх ажлыг зохион байгуулахыг Нийгмийн эрүүл мэндийн газар /Э.Галбадрах/-т даалгасугай.
3. Төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх үйл ажиллагааг Эрүүл мэндийг дэмжих сан болон бусад эх үүсвэрээс санхүүжүүлэхийг Төрийн нарийн бичгийн дарга /Э.Содномжамц/-д зөвшөөрсүгэй.
4. Мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлыг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж, хийсэн ажлын тайланг жил бүрийн 5, 11 дүгээр саруудад багтаан тус яамны Уламжлалт анагаах ухааны хэлтэст ирүүлж ажиллахыг харьяа эрүүл мэндийн байгууллагуудын дарга, захирал нарт үүрэг болгосугай.
5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Б.Баярт/-т даалгасугай.



081113

Эрүүл мэндийн сайдын
2018 оны 06 сарын 20. өдрийн
дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

Хүн амьг уламжлалт анагаах ухааны аргаар эрүүл мэндээ хамгаалах, сайжруулах мэдлэг
арга барилтай болгох мэдээлэл, сургалт сурталчилгаа хийх ажлын төлөвлөө

№	Үйл ажиллагаа	Хариуцах нэгж	Хамтран ажиллах нэгж, байгууллага	Хэрэгжих хугацаа	Шалтуур үзүүлэлт
1. Сургалт					
1.1	Ерөнхий боловсруолын сургуулийн эрүүл мэндийн хичээлийн хөтөлбөрт уламжлалт анагаах ухааны аргаар өвчинөөс урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах	ЭМЯ-ны НЭМГ, УАУ-ны хэлтэс	БСШУСЯ	2018 оны II-III улиралд	Сургалтын хөтөлбөрт нэмэлт оруулах асуудлыг шийдвэрлүүлсэн байна.
1.2	УАУ-ны аргаар өвчинөөс үрьдчилан сэргийлэх мэдлэгтэй болгох чиглэлээр иргэдэд зориулсан сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулах	АШУУС-ийн МАУОУС, УАУ-ны эмч, судлаачдын нийгэмлэг	УАУ-ны мэргэжлийн зөвлөл	2019 онд	Сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулсан байна.
1.3	Иргэдэд зориулсан сургалт зохион байгуулах	Харьяа эмнэлгүүд, УАУТХ, ТБ	НЭМҮТ	2018-2020 он	Сургалт зохион байгуулж тайланг ЭМЯ-ны УАУХ-т ирүүлсэн байна.
2. Мэдээлэл, сурталчилгаа хийх					
2.1	Иргэдэд зориулсан "Уламжлалт аргаар эрүүл мэндээ хамгаалъя" нэртэй фейсбуук хуудсыг нээж ажиллуулах	УАУ-ны эмч судлаачдын нийтэмплэг	УАУХ	2018 оны 07 сар	Мэдээллийг тогтмол шинэчилсэн байна.
2.2	Монголын уламжлалт анагаах ухааны хөгжил, түүхэн эх сурвалжийн талаар олон нийтийн	НЭМҮТ	УАУХ	2018-2020	Мэдээллийг улирал тутам бэлтгэж иргэдэд хүргэсэн байна.

	Мэдээллийн ярилцлага, мэдээллийг бэлтгэн ард иргэдэд хүргэх	Хэрэгслээр ухааны судалгаа сурталчилж шинжилгээний ажлыг сурталчах	УАУХ	Харьяа эмнэлэг болон эмийн үйлдвэр	2018-2019	Үйл ажиллагааг сурталчилсан байна.
2.3	Уламжлалт тусlamж үйлчилгээ болон эм үйлдвэрлэл, шинжилгээний ажлыг сурталчах	УАУХ	Харьяа эмнэлэг болон эмийн үйлдвэр	Харьяа эмнэлэг, эмийн үйлдвэр	2018 оны 09 сард	Өдөрлөг зохион байгуулсан байна.
2.4	“Уламжлалт анагаах ухааны аргаар эрүүл мэндээ хамгаалья” сэдэвт нээлттэй өдөрлөг зохион байгуулах	ЭМЯ-ны НЭМГ, УАУ-ны хэлтэс	ЭМЯ-ны НЭМГ, УАУ-ны хэлтэс	ЭМЯТХ, ТББ	2018-2020 он	Мэдээлэл, сургалт сурталчилгааны ажлын тайланг 5, 11-р сард ЭМЯ-ны УАУХ-т ирүүлсэн байна.
2.5	Иргэдэд зориулсан мэдээлэл, материалыг сурталчилгааны боловсруулж, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр түгээх	НЭМҮТ	НЭМҮТ	УАУТХ, ТББ	2018-2020 он	Мэдээлэл, сургалт сурталчилгааны ажлын тайланг 5, 11-р сард ЭМЯ-ны УАУХ-т ирүүлсэн байна.
3. Иргэдэд зориулсан мэдээлэл, сурталчилгааны материалы боловсруулах						
№	Боловсруулах мэдээлэл, сурталчилгааны материалын сэдэв					Боловсруулах байгууллага
1	Уламжлалт эмийн зохиистой хэрэглээ, гаж нөлөө					Уламжлалт анагаах ухаан, нийтийн эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагууд
2	Уламжлалт эмийн амт, чадал, эрдмийн талаар					
3	Жоргүй олгох уламжлалт эм, эмийн хэлбэрүүдийг хэрэглэх ерөнхий заавар					
4	Эмийн ургамлыг хайлрах, хамгаалах талаар					
5	Уламжлалт анагаах ухааны засал, эмчилгээний онцлог, эмчилгээний дараа гам хийх шалтгаан, ач холбогдол					
6	Эрүүл мэндээ хамгаалах, өвчинөөс урьдчилан сэргийлэхийн тулд явдал мөр, идээ ундааг хэрхэн зохицууллах талаар					
7	Өвчинөөс урьдчилан сэргийлэх талаар улирлын чанартай мэдээлэл, зөвлөгөө					
8	Өндөр насттан, хуухэд, эмэгтэйчүүдэд зориулсан мэдээлэл					
9	Биеийн өвөрмөц байдал (өвөрчлөл)-ыг тогтоох аргад сургалцах гарын авлага					
10	УАУ-ны аргаар өвчинөөс урьдчилан сэргийлэх мэдлэгтэй болгох чиглэлээр иргэдэд зориулсан гарын авлага боловсруулах					

Эрүүл мэндийн сайдын
2018 оны 06 сарын 20 өдрийн

дугаар тушаалын 2 дугаар хавсралт

Хүн амыг уламжлалт анагаах ухааны аргаар эрүүл мэндээ хамгаалах,
сайжруулах мэдлэг, арга барилтай болгох мэдээлэл, сургалт сурталчилгаа
хийх ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах төсөв

№	Үйл ажиллагаа	тоо хэмжээ	Шаардлагатай төсөв, ₮
1	УАУ-ны аргаар өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдлэгтэй болгох чиглэлээр иргэдэд зориулсан гарын авлага боловсруулах	2	20 000 000
2	Иргэдэд зориулсан сургалт зохион байгуулах	хөдөө - 5 удаа, хотод – 9 удаа	8 622 000 580 000
3	Иргэдэд зориулсан мэдээлэл, сурталчилгааны материал боловсруулах	8	30 000 000
4	Нийт зардал		59 202 000